



Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 04–ний өдрийн нэгдсэн чуулганаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталж, 2023 оны 3 дугаар сарын 01–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 3 дугаар сарын 13, 2024 оны 12 дугаар сарын 27–ний өдрүүдэд дараах 3 журмыг баталсан. Үүнд:

- » Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл үйл ажиллагааны журам
- » Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам
- » Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам



Дараах QR кодыг уншуулж одоо мөрдөгдөж буй журмуудтай танилцаарай.

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ ВЭ ?

Тус үйл ажиллагааг дараах 2 хэлбэрээр эрхэлж болно.



### ХУУЛИЙН ЭТГЭЭД

Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээд эрхлэх бөгөөд **зөвхөн хөдлөх эд хөрөнгө барьцаалах** эрхтэй.



### МОНГОЛ УЛСЫН ИРГЭН

Байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий этгээдэд бүртгүүлсний үндсэн дээр Монгол Улсын иргэн эрхэлнэ.

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ нь 10,000,000 төгрөг, түүнээс дээш



Мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад хамрагдсан байх



Банкны харилцах данстай байх



Татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх




Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол тухайн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, стандартыг хангасан ажлын байртай байх



Мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдсон шаардлагатай мэдээлэл авах боломжийг хангасан цахим бүртгэлтэй байх



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежер нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд, гэмт хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй, журмын талаарх сургалтад хамрагдсан байх



Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн талаар мэдээллийг агуулсан цахим мэдээлийн санд холбогдсон байх




Эрүүгийн хуулийн Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Эдийн засгийн гэмт хэрэг, Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ



Улаанбаатар хотод мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх 300,000,000 төгрөг, түүнээс дээш, орон нутагт 100,000,000 төгрөг, түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй хуулийн этгээдийг **Санхүүгийн зохицуулах хороо** бүртгэнэ.



Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1–т заасны дагуу тус үйл ажиллагаанд **Санхүүгийн зохицуулах хороо** хяналт тавина.

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХДЭЭ ЮУГ АНХААРАХ ВЭ?

1

Зээлийн хүү нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааны Бодлогын зөвлөлийн тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээнээс илүүгүй байх.

2

Зээлийн хүүг ашигласан хугацаагаар нь тооцох бөгөөд хүүг урьдчилан авахыг хориглоно.

3

Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ нь үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй байна.

4

Зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээ байгуулахад аливаа шимтгэл, хураамж, эсхүл нэмэлт төлбөр авахыг хориглоно.

5

Анз буюу торгууль, алданги тооцохыг хориглоно.

6

Зээл олгох, эргэн төлөлт хүлээн авахдаа зөвхөн зөвшөөрөлтэй этгээдалбан ёсны дансаар авна.

7

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6–д заасны дагуу Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлээгүй иргэн байнга, ашиг олох зорилгоор хүү тогтоосон зээлийн гэрээ байгуулж, зээл олгосон бол хүү авах эрхээ алдана.

## ЗЭЭЛИЙН ХҮҮ, НЭМЭГДҮҮЛСЭН ХҮҮГ ХЭРХЭН ТООЦОХ ВЭ?

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс гэрээний үндсэн дээр зээлдэгчид олгосон мөнгөн хөрөнгийг ашигласны хариу төлбөрийг “Хүү” гэх ба зээлийн хүүг ашигласан хугацаагаар ердийн хүүгээр тооцно.

**Жишээ 1:** Иргэн Батаа өрхийн хэрэгцээндээ зориулан барьцаалан зээлдүүлэх газраас 500 000₮-ийг 30 хоногийн хугацаатайгаар сарын 4.5%-ийн хүүтэй зээлсэн ба 28 хоногийн дараа зээлийг бүрэн төлж дууссан бол тус хугацааны хүүг хэрхэн тооцоолох вэ?

**Нэг өдрийн хүүг тооцохдоо:**

$$\text{Нэг өдрийн хүү} = 4.5\% * 12/365 = 0.15\%$$

**28 хоногийн ашигласан хугацааны хүүг тооцохдоо:**

$$\text{Хүү} = 500\,000₮ * 0.15\% * 28 = 21\,000₮$$

“Нэмэгдүүлсэн хүү” гэж гэрээнд заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөөгүй тохиолдолд Иргэний хуульд заасан хувиас хэтрэхгүй хувь хэмжээгээр үндсэн хүүг нэмэгдүүлж тооцсон хүүгийн хувь хэмжээг ойлгоно.

**Жишээ 2:** Иргэн Батаа өрхийн хэрэгцээндээ зориулан барьцаалан зээлдүүлэх газраас 500,000₮-ийг 30 хоногийн хугацаатайгаар сарын 4.5%-ийн хүүтэй зээлсэн ба 42 хоногийн дараа зээлийг бүрэн төлж дууссан бол тус хугацааны хүүг хэрхэн тооцоолох вэ?

**Нэг өдрийн хүүг тооцохдоо:**

$$\text{Нэг өдрийн хүү} = 4.5\% * 12/365 = 0.15\%$$

**12 хоногийн хугацаа хэтэрсэн нэмэгдүүлсэн хүүг тооцохдоо:**

$$\text{Нэмэгдүүлсэн хүү} = 500\,000₮ * (12 * 0.15\%) * 20\% = 1\,800₮$$

$$\text{Нийт зээлийн төлбөрт} = 31\,500₮ + 1\,800₮ = 33\,300₮$$

Барьцаа хөрөнгийг зээлдэгчтэй харилцан тохиролцож, бодитой үнэлнэ.



Зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй бол



## ЗЭЭЛДҮҮЛЭГЧ НЬ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭЭР БҮРТГҮҮЛСЭН ЭСЭХ



Иргэн та бүртгүүлээгүй этгээдээс зээл авсан тохиолдолд Барьцаа хөрөнгөө алдах эрсдэлтэй болохыг анхаарна уу.

Бүртгэлгүй этгээдээс мөнгөн зээлийн үйлчилгээ авах нь барьцаа хөрөнгөө алдах, мөнгө угаах болон залилах гэмт хэргийн хохирогч болох эрсдэлтэй.



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэлтэй эсэхийг шалгана уу.

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ



Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, зохицуулах, холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд орон тооны бус Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийг байгуулсан.

Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загварыг батлах;



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох.